

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хийж, “Аймгийн аварга малчин шалгаруулах журамд өөрчлөлт оруулах тухай”, “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай”, “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай”, “Хөрөнгө актлаж сэлбэгээр ашиглах зөвшөөрөл олгох тухай”, “Нэрэмжит болгох тухай”, “Аймгийн хэмжээнд 2018 онд үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хязгаар батлах тухай” тогтоолуудыг гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, ажлын албаны удирдлагууд Оросын холбооны улсын Тыва улсын Их дээд Хурлын Төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, гаргаж буй бодлого, тогтоол шийдвэр, анхан болон дунд шатны хурлын байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, иргэдийн оролцоо, өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж буй байдлын талаар туршлага судлан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:

“Ард иргэдээ сонсох аян”-ын хүрээнд “Төрийн цогц үйлчилгээг багт” хөтөлбөрийг 90 гаруй төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг 2018 оны 08 дугаар сарын 15-24-ний өдрийн хооронд аймгийнхаа 24 сумын хөдөөгийн багт хэрэгжүүлж, 6000 гаруй иргэдэд төрийн цогц үйлчилгээг багт нь хүргэж, давхардсан тоогоор 4900 гаруй иргэдэд нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, оношлогоо хийж, заавар зөвлөгөө өгч, 1900 гаруй иргэдийн үсийг үнэ төлбөргүй засах арга хэмжээг зохион байгуулж, тэдний санал хүсэлтийг сонслоо.

Энэхүү аяны хүрээнд аймгийн Засаг даргын 2018 оны эхний хагас жилийн ажлын тайлан, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг танилцуулах,

төрийн байгууллагуудын үйл ажиллагаа болон удирдлагын ажлыг ард иргэдээр үнэлүүлэх, 2019 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд санал авах, Завхан аймгийн 9 гайхамшигт газрыг тодруулах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга Д.Батсайханаар ахлуулсан 27 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Асгат, Баянтэс, Баянхайрхан, Тэс, Нөмрөг, Түдэвтэй сумдын 20 багийн 2248 иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж, 1593 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, эхо оношлогоонд хамруулан, зөвлөгөө өгч, 654 иргэнд үсчний үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Балхярваагаар ахлуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Тэлмэн сумдын 17 багийн 717 иргэдэд төрийн үйлчилгээг хүргэн, 783 иргэнд эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, 382 иргэний үсийг засч үйлчиллээ.

Аймгийн Засаг даргын орлогч Б.Ариунаагаар ахлуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Отгон, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Яруу сумдын 18 багийн 1432 иргэдэд төрийн үйлчилгээ хүргэлээ. Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, эхо, оношлогоонд 692 иргэнийг хамруулан, 2 иргэний элэгний голомтын өөрчлөлтийг илрүүлж, Улаанбаатар хотод онош тодруулахыг зөвлөсөн бол дотрын эмчийн үзлэгт 608 иргэн, шүдний эмчийн үзлэгт 216 хамрагдаж, 40 иргэнд зөвлөгөө өгч, 112 иргэний шүдийг авах, ломбодох, эмчлэх арга хэмжээг авч, үсчний үйлчилгээнд 325 иргэний үсийг үнэ төлбөргүй засч, үйлчиллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Лхамсүрэнгээр ахлуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сантмаргац, Сонгино, Цэцэн-Уул, Алдархаан сумдын 11 багийн 949 иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж, дотрын эмчийн үзлэгт 638 иргэн, 75 хүүхэд, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг оношлогоонд 677 иргэн хамрагдаж, 496 иргэн үсчний үйлчилгээ үзүүлж, аймгийн Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид ая дуугаа өргөн, төрийн үйлчилгээг багт хүргэлээ.

Уулзалтын үеэр сум хоорондын хилийн зааг, оюутны сургалтын төлбөрийн зээл, орон нутгийн чанартай зам давааны засвар үйлчилгээг хийх, халамжийн асаргааны тэтгэмж гэхчлэн санал хүсэлтийг иргэд ажлын хэсгийн холбогдох албаны



төрийн албан хаагчдад тавьж тодорхой хариултыг авлаа. Мөн үеэр энэхүү төрийн үйлчилгээг малчдын хотонд нь ирж үзүүлж буйд талархаж буйгаа олон малчин илэрхийлж төрийн албаныхандаа ажлын амжилт хүслээ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

2.1. Татвар төлөлтийн байдал:

Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 123.2 хувийн биелэлттэй, 6 тэрбум 676.6 сая төгрөгийн орлого оруулсны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 40.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 4.3 хувь, ашигт малтмал ашигласны төлбөр 20.6 хувь, бусад нэр төрөл 34.9 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 72.9 хувь буюу 4 тэрбум 865.2 сая төгрөгийг орон нутгийн орлого, 27.1 хувь буюу 1 тэрбум 811.4 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 7 сарын байдлаар гүйлгээнд 8 тэрбум 155,8 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 66.4 мянган иргэний 84.5 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 15 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр 82.9 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувь буюу 4.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар Хаан банк 1,53 хувь, Хас банк 0.58-2.0 хувь, Төрийн банк 1.55 хувь, Капитал банк 1.5 хувь байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: 2018 оны 08 дугаар сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны 15, Боловсон хүчний 2 захирамж гарсан байна. Тухайлбал: Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргасан. Завхан аймаг дахь Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн алба хаагч нар "Орон нутгийн зам- хөдөлгөөний соёл" аяны хүрээнд улсын чанартай Тэлмэн, Тосонцэнгэл, Сонгино, Нөмрөг, Их-Уул, сумдын авто замд хяналт шалгалтыг эрчимжүүлэн жолооч нарт хамгаалах бүс хэрэглэх, жолооны ард гар утсаар ярихгүй



байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар анхааруулга санамж тараан ажиллаж байна.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:

Аймгийн хэмжээгээр 139 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 33.1 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 38.9 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 28.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 36-аар буюу 35.0 хувиар өссөн байна.

Эхний 7 сард гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 53 хүн гэмтэж 430.8 сая төгрөгийн хохирол учирсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр 3109 зөрчил илрүүлж, 404 хүн эрүүлжигдэн, 134 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 1514, баривчлагдсан хүн 17-өөр тус тус буурч, эрүүлжигдсэн хүн 3-аар өссөн байна.

3.3. Архивын ажлын мэдээлэл:

2 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн программд оруулах ажлын хүрээнд 1425 хуудас баримтаас 1255 заалт, 4129 хүний нэр, 1143 байгууллагын нэр, 41 PDF файл үүсгэн эх баримтыг мэдээллийн санд холболлоо.

Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 2 хөмрөг, 2 данс, 39 хадгаламжийн нэгжийн 2683 хуудас баримтыг сканердаж, 2 хөмрөг 2 дансны 39 хадгаламжийн нэгж, 2683 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа. 2 хөмрөгийн 112 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан. 206 иргэний хүсэлтийг хүлээн авч 615 баримт шүүж, 203 хуулбар, 360 лавлагаа, 52 тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд 141 хадгаламжийн нэгж баримт ашиглуулсан. 2018 онд нөхөн бүрдүүлэлт хийх судалгаа хуваарийн дагуу 6 хөмрөг үүсгэгчийн 488 хадгаламжийн нэгж баримт хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийлээ.

3.4. Онцгой байдал:

Завхан аймгийн нийт нутгаар 08 дугаар сард оир ойрхон усархаг бороо орсноор Улиастай, Богд, Чигистэй, Идэр, Ширээ, Буянт голууд үерлэж хүн, мал машин техник саатсан боогдсон дуудлага эрс нэмэгдсэн тул үер уснаас сэрэмжлүүлэх нэгдсэн арга хэмжээг Улиастай сумын “Чигэстэй” “Жинст” “Жаргалант” “Богдын гол” багийн 350 өрхийн 1200 иргэнийг хамруулан зохион байгуулсан.



Үер уснаас сэрэмжлүүлсэн 800 ширхэг гарын авлага материалыг жалга судаг, уулын ам, голын дагуу суурьшиж буусан өрхүүдэд тарааж голын захаар үер уснаас сэрэмжлүүлсэн самбар байршуулсан.

Орон нутгийн Шинэ Завхан, Air-1, телевизид сэрэмжлүүлэг шток 18 удаа ярилцлага 4, сонин хэвлэлд 2, Вэб сайтад мэдээлэл 4, EM радиогоор сэрэмжлүүлэг 4, “Очир-Илч” Баруун бүсийн худалдааны төв, Улиастай захын узелүүдээр цаг аагрын сэрэмжлүүлэг мэдээнүүдийг тухайн бүрд нь хүргэж ажилласан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа: Монгол улсын Шадар сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу аймгийн Улиастай сумын Шунхлай, Ник-петровис, Магнай трейд, Ундрага петролиум зэрэг нийт 11 ШТС-уудад Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч Б.Амарсанаа, Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Э.Батжаргал нар 2018 оны 08 дугаар сарын 01-ээс 08 дугаар сарын 26-ны хооронд хяналт шалгалт зохион явууллаа.

Мөн Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дөрвөлжин, Ургамал сумдын нутагт уурхай, уулын үйлдвэрлэл явуулж буй 5 газруудыг хамруулан хяналт шалгалтын ажлыг зохион явуулж, шалгалтын хүрээнд галын аюултай материал хадгалах, ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахдаа эрх бүхий байгууллагын мэргэжлийн дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөл авах журам зөрчсөн 2 газарт тус бүр 1 сая төгрөгний торгууль оногдуулсан.

Шалгалтаар: Объектод байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, нормативын дагуу байрлуулаагүй, гамшгаас хамгаалах болон гал унтраах шуурхай төлөвлөгөөгүй, гамшгаас хамгаалах эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийлгээгүй, ажилчдад гамшгаас хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулаагүй, гал унтраах ангитай холбогдох найдвартай холбооны хэрэгсэл байрлуулаагүй, гадна рекламн металь самбаруудыг нэгдсэн газардуулгад холбоогүй, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогүй, гал унтраалгууд цэнэг дууссан, ойр орчмын өвс, ургамлыг цэвэрлээгүй, тос хадгалах өрөөнд агааржуулагч хийгээгүй, галын болон бусад ослын үед техник, тоног төхөөрөмжийг зогсоох дарааллыг товч харуулсан бүдүүвчийг ил байрлуулаагүй зэрэг нийтлэг зөрчил дутагдлууд илэрсэн.

Дээрхи зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 9 үйлдэн хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад

хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар нийт 31 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Байцаагчаас үйлдсэн эрх зүйн баримт бичгийн талаар: Заавал биелүүлэх албан шаардлага 7, Гал түймэр гарсан тухай акт 1, Зөрчлийн тэмдэглэл 1, Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 3, Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 1 тус тус бичсэн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: 8 дугаар сарын 03-06 нд *Хүүхдэд ээлтэй орон нутаг* санаачилгыг хэрэгжүүлэн ажиллаж буй Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгийн үйл ажиллагаа, ажлын үр дүн, эерэг өөрчлөлтийг хэлэлцэх, харилцан суралцах, хамтын ажиллагаа, үндэсний түвшинд туршлагаа таниулан дэмжлэг авахад нөлөөлөх, цаашдын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд оршино. Сургалтанд зорилтот аймгийн хүүхдэд ээлтэй хөтөлбөрийн ЗДТГ, НҮБ-ын хүүхдийн сан, Зохицуулах зөвлөлийн дарга нар, ГБХЗХГ, БСУГ, ЭМГ-ын төлөөлөл нийт 60 хүн оролцлоо.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Насан туршийн боловсролын үндэсний төвөөс "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах арга зүй" бүсчилсэн сургалтыг 2018 оны 08 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Архангай аймагт амжилттай зохион байгуулж, Архангай, Завхан аймгийн Насан туршийн боловсролын төв, нэгжийн багш нар хамрагдаж, сургалтанд НТБҮТ-ийн Захирал Л.Болортунгалаг ахлуулан НТБҮТ-ийн арга зүйч Эрдэнэчимэг, Баянгол дүүргийн НТБТөвийн менежер Оюунгэрэл нар сургагч багшаар ажилласан. Завхан аймгийн Нэгжийн 14 багш, Архангай аймгийн НТБТөвийн захирал, арга зүйч, багш нийт 6, нэгжийн 19 багш тус тус хамрагдсан.



4.2. Нийгмийн даатгал, халамж:

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1265 болж, өнгөрсөн оны

мөн үеэс 0.9 хувиар буюу 23 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 693 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 54.8 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 19.2 хувь нь 15-24 нас, 28.9 хувь нь 25-34 нас, 26.1 хувь нь 35-44 нас, 20.5 хувь нь 45-54 нас, 2.7 хувь нь 55-59 нас, 0.4 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 2 хувь нь боловсролгүй, 4.8 хувь нь бага, 7.6 хувь нь суурь, 53 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 21.1 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2018 оны 8 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Увс аймагт зохион байгуулсан Баруун бүсийн сургалт, зөвлөгөөнд нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, аймгуудын дунд явуулсан уралдаан, тэмцээний багийн дүнгээр 2 байранд шалгарсан амжилт гаргав. Зөвлөгөөний үеэр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичиг, шинээр батлагдсан салбарын хуулиуд, тэдгээрийг дагаж мөрдөх дүрэм, журмууд, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 онд дэвшүүлсэн зорилтын үр дүнгийн талаар мэдээлэл өгч, шинээр санаачилсан, бусад аймагт туршлага болохуйц ажлуудын талаар туршлага солилцов. Манай байгууллага уг мэдээллээ телевизийн нэвтрүүлэг байдлаар хийсэн нь шинэлэг санаачилгатай байсан гэсэн үнэлэлтийг ХХААХҮЯ-ны удирдлагуудаас өглөө.

ХХААХҮЯ-аас 2018 оны 08 дугаар сарын 06-11-ны хооронд Дорнод аймагт зохион байгуулагдсан “Хүнсний ногоо” улсын үзүүлэх сургууль, сургалтад Улиастай сумын Д.Цэрэнбалжир тариаланчдын хамт оролцож, газар тариалангийн салбарт нэвтрүүлж байгаа тэргүүн туршлага, шинэ техник, тоног төхөөрөмжийн талаар туршлага судаллаа.

Монгол ногоо төслийн газартай хамтран Лааны булан, Ногоон хашаа, Өндөр толгой, Ногоон булангийн услалтын систем түшиглэн улаан хальст сармис тариалж байгаа 11 өрхийн сармиснаас 159 дээжийг Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй хамтран авч, вирусийн гаралтай өвчин болон хортон шавжийн шинжилгээг хийлгүүлж байна.

Аймгийн хэмжээнд ургацын урьдчилсан балансыг гаргаж ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлээд байна.

Урьдчилсан балансаар үр тариа 1190 тн, малын тэжээл 1079.6 тн, төмс 2077 тн, хүнсний ногоо 1409.9 тн-ыг хураан авахаар урьдчилсан мэдээтэй байна

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Байгаль орчин, аялал жуулчлалын газар Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай хамтран 2018 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Алдархаан сумын богдын гол багийн Өвт, Рашаантын гол, Цагаан нуурын 10 айл өрхөөр орж Зөрчлийн тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хуулийг сурталчилж ажилласан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд 08 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Улиастай сумын 4 постонд гарч 100 гаруй тээврийн хэрэгсэл шалган 5 иргэний нийт 8 тарвага, 5 загас хураан авч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэхээр шалгаж байна.



Аймгийн ИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сургийлэх салбар зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Зоонозын өвчин судлалын төвүүд хамтран Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн а/278 дугаар тоот тушаал буюу Монгол тарвагыг ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар агнахыг 3 жилийн хугацаатай хориглосонтой холбогдуулан эргүүл шалгалтанд гарч аймгийн төвөөс гарч буй



тээврийн хэрэгслүүдэд тарвага агнахыг хориглосон брошур 89 ш, балкад 20 сумд 50 гаруй ширхэгийн тараасан.

2018 оны 08 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Дөрвөлжин сумын Буурал багийн нутагт дэвсгэрт зөвшөөрөлгүй хайгуулын үйл ажиллагаа явуулж буй XV-014381 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй СДДГ ХХК-ний үйл ажиллагааг зогсоосон.



6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7 сарын байдлаар оны үнээр 5999.2 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 19.5 хувиар буюу 1450.4 сая төгрөгөөр буурч нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 4338.4 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 1660.8 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 55.8 хувийг, хүнсний үйлдвэрлэл 30.1 хувь, хувцас үйлдвэрлэл 7.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 4.2 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.2 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.9 хувь, Болк тоосго үйлдвэрлэл 0.9 хувь , бусад үйлдвэрлэл 0.5 хувийг тус тус эзэлж байна.

6.3. Дэд бүтцийн чиглэлээр: 2018 онд аймгийн Засаг даргын үндсэн чиглэлд хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн Отгон, Цэцэн-Уул сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан Цэцэн-Уул суманд ажлын хэсэг 2018 оны 08 сарын 22-ны өдрөөс 08 сарын 26-ны өдрийн хооронд ажиллалаа.

Уг ажлаар сумын удирдлагууд болон 5 багийн Засаг дарга нар, иргэд, малчид, тариаланчидтай уулзан төлөвлөгөөний талаарх танилцуулгыг хийж санал хүсэлтийг аван сумын төвийн хуучин газар доорх шугам сүлжээг тодотгон зураглал хийлээ.



Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин баригдаж байгаа Улиастай сумын 800 хүний суудалтай Хөгжимт жүжгийн театрийн барилга угсралтын ажлыг “Эл Си Би” ХХК гүйцэтгэж байгаа ба 2018.04.15-наас ажлаа эхлэн 1 ба 2-р давхарын өрлөг , Тайзны хэсгийн цутгалтын ажил хийгдэж байна. Үе шатны техникийн хяналтыг 6 удаа гүйцэтгэж зөвлөх үйлчилгээ үзүүлж зургийн дагуу барилгын норм дүрэм, стандартыг хангуулж ажиллаж байна. Авторын хяналтыг газар дээр нь дуудаж зургийн өөрчлөлтөд зөвшөөрөл авч 2 удаа хамтарч ажилласан.



Отгон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг “Засагтхан констракшн” ХХК тендерт гүйцэтгэгчээр шалгарч Аймгийн Засаг даргын 2018 оны 08 сарын 14-ний өдрийн А/368 тоот захирамжын 4-р хавсралтаар ажлын комиссын бүрэлдэхүүнийг томилон ашиглалтанд хүлээлцсэн.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР